



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР**

2024 оны 12 сар

**Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний
хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн,
Эрүүл мэндийн яам, 2024 оны жилийн эцсийн байдлаар**

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлагдсан.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах бодлогын Эрүүл мэндийн салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, өвчлөл, нас баралтыг бууруулна Зорилго 3.3-ын хүрээнд Эрүүл мэндийн яам үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар нийт 10 арга хэмжээ тусгагдсан байна.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ тус бүрийн хүрсэн түвшинг тодорхойлох, хүлээгдэж буй үр дүндээ хүрэх боломжтой эсэхийг нягтлах, арга хэмжээг эрчимжүүлэх санал, зөвлөмжийг боловсруулах, шийдвэр гаргагч нарыг мэдээллээр хангах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэсэн болно.

Хоёр. Хяналт-шинжилгээ үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлгээг хийж, журмын дөрөвдүгээр хавсралт ёсоор тайланг нэгтгэн гаргасан. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг журмын 6.2.2, 6.2.3 дугаар заалтын дагуу бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх аргачлалыг баримтлан хэрэгжилтийг хувиар тооцсон.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан эрүүл мэндийн салбарын 10 арга хэмжээний хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 56.03 хувьтай үнэлэгдсэн.

“Үр дүнтэй” 4 (40.0%) арга хэмжээ:

1. 3.3.1.1. Эмийн нийлүүлэлт, худалдан авалтыг оновчтой зохион байгуулж, эмийн чанарыг сайжруулах (СТГ);
2. 3.3.2.6. Бүх шатны эмнэлэг, эмийн сангуудад ашиглагдах нэгдсэн өгөгдлийн систем үүсгэх /өвчний түүх, эмчилгээний түүх, эмчийн онош, жор/: Системд холбогдсон эмнэлэг (СТГ);
3. 3.3.2.6. Системд холбогдсон эмийн сан (СТГ);
4. 3.3.2.8. Телемедицин нэвтэрсэн эрүүл мэндийн байгууллагыг нэмэгдүүлэх (СТГ).

“Тодорхой үр дүнд хүрсэн” 1 (10.0%) арга хэмжээ:

1. 3.3.2.5. Эмчилгээний хамгийн сүүлийн үеийн зааварчилгаа, туршлага хуваалцах платформд бүрэн холбогдох /UpToDate/ (ЭТБГ).

“Эрчимжүүлэх шаардлагатай” 2 (20.0%) арга хэмжээ байна. Үүнд:

1. 3.3.2.1. Сүрьеэгийн эмнэлэг барих ажлыг үргэлжлүүлэх (СЭЗБГ);

2. 3.3.2.7. Монгол Улсад оношлогдох, эмчлэгдэх боломжгүй өвчний чиглэлээр технологи нэвтрүүлэх (ЭТБГ).

“Үр дүнгүй” 3 (30.0%) арга хэмжээ байна. Үүнд:

1. 3.3.2.2. Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилга барих (СЭЗБГ);

2. 3.3.2.3. “Хавдар судлалын үндэсний төвийн салбар II”-ын барилга барих (СЭЗБГ);

3. 3.3.2.4. Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих (СЭЗБГ).

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 10 арга хэмжээнд нийт 127,600.00 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 3 арга хэмжээнд улсын төсвөөс нийт 5.8 тэрбум төгрөг зарцуулсан байна. Үүнд:

- 3.3.1.1. Эмийн нийлүүлэлт, худалдан авалтыг оновчтой зохион байгуулж, эмийн чанарыг сайжруулах - 607.0 сая төгрөг;

- 3.3.2.5. Эмчилгээний хамгийн сүүлийн үеийн зааварчилгаа, туршлага хуваалцах платформд бүрэн холбогдох /UpToDate/ - 1.8 тэрбум төгрөг;

- 3.3.2.7. Монгол Улсад оношлогдох, эмчлэгдэх боломжгүй өвчний чиглэлээр технологи нэвтрүүлэх - 3.4 тэрбум төгрөг.

Дөрөв. Дүгнэлт

1. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан эрүүл мэндийн салбарын 10 арга хэмжээний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 56.03 хувь буюу “Эрчимжүүлэх шаардлагатай” гэсэн үнэлгээтэй байна.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар улсын төсвөөс 5.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна.

3. Сүрьеэгийн эмнэлэг, Эрхтэн шилжүүлэн суулгах төв, Хавдар судлалын үндэсний төвийн салбар II, Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдэхгүй байснаас “Үр дүнгүй” болон “Эрчимжүүлэх шаардлагатай” үнэлгээтэй байна.

Тав. Зөвлөмж

Хөгжлийн төлөвлөгөөний арга хэмжээнээс 70-аас доош хувийн үнэлгээтэй буюу “Эрчимжүүлэх шаардлагатай”, “Үр дүнгүй” гэсэн 5 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтийн явцад хяналт тавих шаардлагатай байна.

Эрүүл мэндийн яам
2024 оны 12 дугаар сарын 27